

## Тоо гүүргийлэлцэж явлаа хө

### 1. Цэргийн ёсоор ажилласан цаг

Эрдэнэсантаас дайчлагдсан Θ.Хаянхярваагаар даргалуулж, Баянбараатаас дуудагдсан С.Дашням, Сэргэлэнгээс авчирсан Д.Цэрэнхүү, Баянчандманиас ирүүлсэн Лувсан-Ёндон нар анхны тоо бүртгэгчид нь болж нэгэн жижиг хамтлаг бүрдүүлсэн нь жараад оны босгонд болсон хэрэг.

Дайны үеийн цэрэг явцгааж аранзал тугийн намираан доор алтан нутгаа хамгаалж, дарийн утаа үнэрлэж, харийн дайсан даралцаж хамгаалж дарийн утаа үнэрлэж харийн дайсан дараалдцаж хал үзэж хашир таньсан, бас цэргийн даргын ширэн цүнхэндээ сумын засаг тамгатай албаа багтааж ард амьтаны дунд л морин дэл дээр ажиллацааж ирсэн шагхийсэн албан хаагчдаа аймаг дайчилан авчирсан нь юун буй?

Нам засгийн шийдвэр гарч төв аймгийн хөдөлмөрчидийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд тоо бүртгэлийн товчоо бий болсон нь тэрээ! Сандагийн Дашням нь Баянбараатын уугул. Багаасаа Ижрэгийн жаст, шавилан түвш монголбичиг үсэг сурч Монгол тээх хэмээн автын анхны баазад орос мэргэжилтний заавраар слесарьч явах цагтаа латин олон шинэ үсэг суралцаж бурхны номын унзад, марксизмын суртал номлогч сумандaa тэргүүн сампинчин гээд номын ухаантай эр. Баянбараат сумын даргаар сонгогдоод ажиллаж байхад аймагт татан төлөвлөгөөний комиссын мэргэжилтэн тоо бүртгэгчээр ажиллуулж явтал сумын сонгууль таарч нутгийнх нь ардууд ахиад даргаараа сонгочихсон .... Учир тоо бүртгэлийн товчоо нэг сайн ажилтнаа арга буюу явуулсан гэнэ.

Лувсан\_Ёндон гэж Баянчандмань сумын Замтын нэгдлийг улсад нэр гарч мандахад нь санхүүг нь эрхлэн хөтөлж ирсэн сайн нягтлан байлаа. Рэвүзийн Дамдинсүрэн гэж хожмоо тээврийн байгууллагад хүч зүтгэсэн сайн нягтлан байлаа.

-би ийм л хүмүүстэй ажиллах болчихлоо.

Эд нар наад зах нь мундаг сампинчингууд. Миний эрдэм гэж маруухан даа.

Сэргэлэн сумыг Ганц худагт төвлөрч бүхийд бага сургууль дүүргээд, аймгийн төвд 5 дугаар ангид сууснаа гэр, мал гэсхийгээд харьчихсан.

1954 онд цэргээс халагдаж сүү тосны заводын нягтланг бодогч, сумын нарийн бичгийн дарга, сумын гүйцэтгэх захиргааны орлогч дарга явлаа.

Цэрэгт Баянтумний холбоонд радиост бага дарга гээд тоо эрдэмд нэг их гийгсэнгүй. Сумын орлогч болчихоод анх сампин хөдөлгөж ч мэдэхгүй, ардын аж ахуйтны ногдол ноос, ноолуур хөөвөр, хялгас, мал махны даалгавар хуваах, тусгай тариифын дагуу нэгийнх нь илүүгээр нөгөөгийнх нь дутууг нөхнө. Тэгэхэээр тоо бодлого шаардлагатай, сампин мэдэхгүй болохоор цаасан дээр л зураад байна.

Инээдэмтэй байгаа биз. Хичээл шамдлага ажил бүтээх гэсэн чинь эрмэлзэл лу юм сургаж байлаа шүү дээ. Тоонд гайгүй гээд л аймаг дуудаж тоо бүртгэлийн товчоондоо ажиллуулсан хэрэг байжээ.

Дэндэвийн Цэрэнхүү гуай ийн ярьж сууна. Хар ухааныхаа хүчээр ардын сэхээтэн болсон анхны тоо бүртгэгчид хорын харандаа зандан шугам, суман модон самбар,

пинтайгаар өнөөдөрийн жиг жуг аниртай тооцоолон бодох электрон техник бүхий статистикийн албаны тулгын чулууг тулцааж дээ.

Илгэн хүрэн хилэн дээлийнхээ нударгыг эргүүлээд ногоон шляп духодуйлсан баҳим зузаан биетэй бөндгөр улаан бор өвгөн 60 гарсан гэхээргүй жалахтай инээмсэгдлэн сууж 30 гаруй жилийн өмнөх дүрээ эргэн санав бололтой. 1958 онд батлагдсан Улс ардын аж ахуйн соёлыг хөгжүүлэх З жилийн төлөвлөгөөний биелэлтийн мэдээ тайлан бүртгэл гаргаад л өдөр шөнөгүй тоо сампиндаад л зүтгэлтэй гэж амаргүй явлаа.

Яг л цэргийн улс шиг ажилцааж дээ. үүнийхээ хүчинд З жил ажилчихаад намын дээд сургуулийн оюутан болсон юм. Ардын цэрэгт алба хашсан тэр хувьсгалт урам зоригоороо шинэ албаа тэд өөд нь татсан юм байна.

## 2. Дахиад л өнөө албанд

Ертөнцийн З өдөр шиг Цэрэнхүүгийн З гэж бий. Түүний ажил амьдралын зам нь гурав гурван жилийн жигдхэн хэмтэй алхасан нь сонихон тохиолдно.

Сумын нарийн бичгийн дарга З жил, сумын орлогч дарга З жил, аймгийн тоо бүртгэлийн товчоонд З жил, аймгийн намын хорооны лектор З жил, аймгийн статистикийн дарга З жил, Баяндэлгэрийн сумын намын хорооны дарга З жил, аймгийн үйлдвэрчний эвлэлийн зөвлөлд хэлтэсийн эрхлэгч З жил . . . . Ертөнцийн материаллаг нэгдэл, үгүйсгэл үгүйсгэлийн хууль, тусгалын онол гэх буюу хөгшин европоор хий үзэгдэл мэт тэнэж явсан социолист үзэл материаллаг үзэл болсон нь энэ гээд залуухан бүмбагар лектор олныг тойруулан ном айлдаж явтал аймгийн удирдлагад дуудагдаж ээ. Туршлагатай бол туршлагатай, сургуультай бол сургуультай чи хий гээд гаргаж дээ.

үгүй гэх ам байх биш үзээд тавьчихжээ. Намын шинэ программ батлагдаад удаагүй Лениний 100 жилийн ой ардын хувьсгалын 50 жил гээд төлөвлөгөө ч гэж шахуу, уралдаанг ч гэж дайчин, хүмүүсийн идэвх эрмэлзэл ч өндөр.

Энэ л ажил амьдралын оволзсон хөдөлгөөний тоон үзүүлэлт яаж хэлбэлзэж өөрчлөгдж, төлөвлөгөө чанар хэрхэн биелэж явааг маниа статистикийн товчооныхон нойргүй сууцгааж гаргана. Нэг үеийг бодвол мэргэжилтийн боловсон хүчнээр бэхжчихсэн байлаа.

Сургуульд номыг нь заалгаад ирсэн Л.Нацагдорж ахлах мэргэжилтэн, Ц.Бямбаа, С.Амарбат, Зэнэмэдэр, Д\_Аюуш нар ажиллаж байгаа.

Хүснэгт маягт нь ч техник хэрэгсэл нь ч мэдээ авдаг холбоо харилцаа нь ч шинэ төлөв шинжинд орчихсон үе л дээ. Би тоо бүртгэгч байхдаа ХАА-н бүртгэл нарийндаа мал, газар тариалан хариуцаж суусан болохоор түүнээ сайн мэднэ. Бусдыг нь дарга болоод шинээр суралт хэрэгтэй болсон. Аймгийн аль ч дарга ямар ч нөхцөлд тоо асуухад үнэн хариуг нэг их тэвдэлгүй 7-10 хоногийн хэлбэлзэлтэй хэлж явлаа. Тэр л лут уралдаануудыг дүгнэхэд манай тоог баримтлана шүү дээ. Уралдаж байгаа газрууд ч хор шартай.. дүн ахиулсан ч юм гарна. Өвөрхангай, Төв хоёр уралдаанаа дүгнэж хэд хоног маргаж мэтгэлцэж суугаад хожимдсон чармайлт гэж манайхныг шоглоод нийтлэл ч бичигдэж байсан шүү дээ.

Ийнхүү аймгийнхаа ажил амьдралын тоог гүүргийлэлцэж, бас тоочдоо захирч тушааж явсан Цэрэнхүү гуай энэ үеийн ажил үйлдвэрлэлийн толь болгож Төв аймаг хэмээх бэсрэгхэн ном бичсэний нь та уншчихаарай.

### 3.Хуварга дүртэй эрийн хувь бодол

миний марзан дамшиг ярьсан нь:

—Цэрэнхүүгийнх нүүх болж гэнэ. Их нүүдэл болно гэж зар хүргэж дээ. Ажлынхан, найз нөхөд нь ачаалалцааар ачиж ажил ч эхэлж, эр хоймортоо суусаар л байж, Гэрийг нь буулгаж эхэлтэл сая мэдсэн мэт.

толгой дээр нь унъ унааж мэднэ. Би арын алба залгуулна гээд гарчээ. Ачаалж дуустал буурины дэргэд хошин шог ярьж хүмүүсийг хөгжөөсөн шиг сууж л байж. Шинэ нутагт гэрий нь барьсны хойно мань эр машинаас сая бууж хойморт зассан орон дээр суугаад:

Эхнээр мах чана. Гэхэд дуулгавартай авгай нь галлан хоол үйж, мань хүн хоёр гараа өргөсхийж сууж л байж. Хүмүүс ажиллаад...

Эхнэр нь өмнө нь тахил таваг мэт өрөөд л Цэрэнхүү заншсан ёсоор, гүнцэглэж арын албаа ийн залгуулж суусан гэдэг.

үүнийг сонссон Цэрэнхүү гуай инээгээд: Иймэрхүү ярианд даваадуулсан ч үнэний хувь бий. үнэндээ би хүндхэн ч юм өргөж явсангүй. Амьжиргаагаа эхнэр маань аяы нь олчихно.

Би яахав архи тамхи гэх биш цалингаа л аваачаад өгчихнө. Цэвэлмаа маань оёдолчин байх намайг тойлно. Би баярлаж явдаг. Мөрөөрөө зүтгэлтэй хийсэн ажил бүтэмжтэй байв. өөрийгөө хайр хүртсэн хүн л гэж бодож суудаг даа. Москвад курс хийж үзлээ.

Ардын хувьсгалын 40, 50, 60 жилийн ойн медаль шагналаа.

Хамаг цагийг л алба залгуулахад зориулсан уу болохоос биш хувьд чөлөө ч авч үзсэнгүй. Дөчин жил ажиллаад тэтгэвэрт гарлаа.

Олон түмний түшиг, төр засгийн хайраар буянтай л амьдарч явна гэв.

Янз бүрийн албандаа өдөр шөнөгүй зүтгэсэн ч унаган махаа бараагүй, лам төрхийн ямбатай амгалан дүр нь эвдрээгүй Цэрэнхүү гэж Сэргэлэн сумын ард ийм бодолтой, тийм халамжит ханьтай хүн дээ.

(Ш.Цэрэндоогийн "Амьдрал шинжсэн тоочид" номоос)